



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар A/02

Хэрлэнбаян-Улаан тосгон

**2025 оны цэргийн тоо бүртгэл
явуулах тухай**

Монгол Улсын “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1 “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль” -ийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 “Батлан хамгаалах тухай хууль” -ийн 17 дугаар зүйлийн 17.1.4, “Цэргийн албаны тухай хууль” -ийн 34 дүгээр зүйл, Аймгийн засаг даргын 2025 оны Цэргийн бүртгэл явуулах тухай А/675 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тосгоны хэмжээнд 2025 оны цэргийн тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2025 оны 01дүгээр сарын 20 ны өдрүүдэд зохион байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Отгонбаяр -ЗАА Дарга

Гишүүд: Б.Энх-Саруул -Нийгмийн бодлогын мэргэжилтэн
Д.Болормаа -МААХҮТММУБАХ мэргэжилтэн
Э.Энхсайхан - Сургалтын менежер
П.Должин -Номын санч

2. 2024 оны жилийн эцсийн хүн амын тоотой нэг бүрчлэн тулгалт хийж, тоо бүртгэлийн мэдээ судалгааг өгсөн зааварчилгааны дагуу тогтоосон хугацаанд хийж, гаргаж Аймгийн цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч /С.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАХИРАГЧ *Б. Энхцэцэг* Б.ЭНХЦЭЦЭГ

